



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 12 сарын 09 өдөр

Дугаар А/550

Улаанбаатар хот

Г Хан-Уул дүүргийн Албан бус-Насан Г  
туршийн боловсролын төвийн данс бүртгэлд  
хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 3,498,800 /гурван сая дөрвөн зуун ерэн найман мянга найман зуун/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Хан-Уул дүүргийн Албан бус - Насан туршийн боловсролын төв данс бүртгэлд /Ч.Гантуяа/-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Чингэлтэй дүүргийн 144 дүгээр цэцэрлэг /Ч.Гантуяа/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГА  М.БАЯРАА



115060001433

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн 1382 дугаар тушаалын хавсралт



Бүртгэлд авах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Хан-Уул дүүргийн Албан-Насан туршийн боловсролын төв

№	Хөрөнгийн нэр	Марк	Үзүүлэлт	Ашиглал- танд орсон огноо	Чанар байдал	Хэм- жих нэгж	Тоо шир- хэг	Бүртгэлийн үнэ /төгрөгөөр/		Хандивлагч байгуулга	
								Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Нэр	Эх үүсвэр
1	Проектор	Acer	1323 WH	2019	шинэ	ш	1	1,299,900	1,299,900	Нэр	Эх үүсвэр
2	Проекторын дэлгэц	Vega	60*80	2019	шинэ	ш	1	169,900	169,900	"Мандах нар" боловсролын туслалцаа	Хандив
3	Өсгөгч	Sony	Titan7-BTMI	2019	шинэ	ш	1	149,900	149,900		
4	Шулуун оёдлын машин	MAQI	LS-9800/6-1	2019	шинэ	ш	1	931,000	931,000	Дэлхийн зөн Монгол ОУБ	Хан-Уул ОНХ хандив
5	Хэрээсний машин	АСМЕ	320	2019	шинэ	ш	1	948,100	948,100		
									3,498,800		
									<b>3,498,800</b>		
Тоног төхөөрөмжийн дүн											
<b>Нийт бүртгэх хөрөнгийн дүн</b>											